

“ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ АРВАЙХЭЭР НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.09.30

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн “Өвөрхангай аймаг дахь Арвайхээр нисэх буудлын үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 09/22 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг зайнаас хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер Ө.Мөнгөнжигүүр, аудитор О.Сэндэр, Ц.Оюут, А.Мөнх-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрөөс 2022 оны 9 дүгээр сарын 07-ны өдрүүдэд дотоод аудитыг зайнаас хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Өвөрхангай аймаг дахь Арвайхээр (Хархорин, Хужирт) нисэх буудлын 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны төсвийн гүйцэтгэл, зарцуулалт, үр ашгийн байдал, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, албан хэрэг хөтлөлтийн байдал, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, нисэх буудлын үйл ажиллагаатай холбоотой удирдах дээд байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн хэрэгжилт, албан даалгаврын биелэлт, гадны байгууллага, иргэнтэй хийсэн гэрээ хэлцэл, худалдан авалт, түүний эрх зүйн үндэслэл, хэрэгжилт, нэгжийн бүтэц орон тоо, цалин хөлсний тооцоолол, албан тушаалын тодорхойлолт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

ИНЕГ-ын харьяа Өвөрхангай аймаг дахь Арвайхээр нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайланд Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн ба тус хараат бус аудитын тайлангаар зөрчил дутагдал илрээгүй талаар дурдсан байна.

Тус нисэх буудал нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 505.5 сая төгрөгийн зардлын төлөвлөгөөтэй ажилласан ба гүйцэтгэл нь 476.5 сая төгрөг буюу 29.0 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна..

ИНЕГ-ын ДАА-аас 2021 онд хийгдсэн дотоод аудит хяналт шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийн дундаж хэрэгжилт 91 хувьтай буюу хангалттай байгаа боловч албан хэрэг хөтлөлттэй холбоотой өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай буюу удаашралтай байна.

Дотоод аудитын шалгалтаар нисэх буудлын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт, И-баримт бүрдүүлэлтийн байдал, цалин хөлсний бодолт, тооцооллын байдал, албан томилолтын бүртгэл хөтлөлт, удирдамж, тайлагналын байдал, авто машин, дизель генераторуудын бүртгэл хөтлөлт, шатахуун зарцуулалтын байдлыг шалгахад зөрчил илрээгүй болно.

“Veritech ERP” программын хүний нөөцийн зарим системийг ашигладаггүй, ашиглаж байгаа системийн хувьд мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, бүрэн гүйцэд оруулдаггүй, программд мэдээллийг тогтмол оруулж бүрэн ашиглах талаар хариуцсан ажилтнуудад сануулан, зөрчлийг шалгалтын явцад залруулав.

Ажилчдын 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 8 сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны ажлын цагийн бүртгэлийг харуулууд нь дэвтэрт гараар бүртгэл хийж цагийн тооцоо гаргасан, 2022 оны 8 дугаар сараас нүүр таних төхөөрөмж ашиглаж байгаа ч цаг бүртгэлээ төхөөрөмжөөс гаргаагүй буюу одоог хүртэл гар бүртгэлээр ажлын цагийн



тооцоо гаргаж байна. Мөн 2021 оны ажлын цаг бүртгэлийг шалгахад хуучин хурууны бүртгэл оруулдаг төхөөрөмжөөс ирсэн, явсан цагаар бүртгэлээ гаргадаггүй ажлын өдрийн үргэлжлэх хугацаагаар цаг бүртгэл гаргасан нь алдаатай байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар “Өвөрхангай аймаг дахь Арвайхээр нисэх буудадп 9 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА